

Хяналтын програм хангамжийн техникийн тодорхойлолт

Вэб сайтын Нүүрс тээврийн цахим цонх хэсгийг хэрэглэгчдэд амар хялбар байх үүднээс iOS болон Андроид үйлдийн систем дээр Мобайл аппликейшн хийж интернетэд байршуулах.

1. Дараах модулиудаас бүрдэх болно.

A. **Нүүрс тээврийн гэрээ нь баталгаажсан компаниуд** - Цахим системийн өгөгдлийн сантай тусгай сервисээр холбогдож тухайн өгөгдөлөөс хайлт хийх болон дэлгэрэнгүй харах, олон нийтэд ил тод болгох, хяналт тавих боломжтой байх

B. **Тээврийн шилжилт хөдөлгөөн цэс үүсгэх**

- Энэ цэсэнд Тээврийн шилжилт хөдөлгөөн нь хүлээгдэж байгаа, шилжилт хөдөлгөөн хийгдсэн компаниуд мэдээлэл жагсаалтаар харагдах болно. Вэб сайтын өгөгдлийн сантай тусгай сервисээр холбогдсон байна.

C. **Тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээлэл**

- "C" зөвшөөрөл авсан тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй мэдээллийг Авто тээврийн үндэсний төвийн системтэй холбож API, JSON ашиглах авах
- Тухайн тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээллийг Авто тээврийн үндэсний төвийн системтэй холбож API, JSON ашиглах авах
- Тухайн тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээллийг Авто тээврийн үндэсний төвийн системтэй холбож API, JSON ашиглах авах
- C зөвшөөрөл авсан компаниудын мэдээллийг АТҮТ-ийн вэб сайтаас авч оруулах, мэдээллийг хянах боломжтой байх
- Бүртгэлийн мэдээлэл, тээврийн хяналт, улирлын C зөвшөөрөл хүссэн компаниуд гэх мэдээллийг тус цахим цонхоор өгөх, хяналт тавих боломжтой байх

D. **Тээврийн зар** - Тээврийн зар цэс үүсгээд жолооч нар нүүрс тээвэртэй холбоотой өөрсдийн зарыг нэмэх боломжоор хангаж өгөх. Вэб сайтын өгөгдлийн сантай холбох

E. **Санал хүсэлт** - Тухайн цэсэнд жолооч нар нүүрс тээвэрлэлтэй холбоотой санал хүсэлт оруулах боломжоор хангаж өгөх. Вэб сайтын өгөгдлийн сантай холбох